

БАТЛАВ: УБДС ХК-ИЙН  
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР  
..... Б.БАТБАЯР

УЛААНБААТАР ХОТЫН ТӨВЛӨРСӨН ДУЛААН ХАНГАМЖИЙН ДАМЖУУЛАХ  
СҮЛЖЭЭНИЙ ДУЛААНЫ АЛДАГДЛЫН БОДИТ УТГИЙГ ТОГТООХ,  
МӨРДӨГДӨЖ БАЙГАА НОРМТОЙ ТУЛГАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2019-01-17

АЖЛЫН ДААЛГАВАР:

Эрчим хүчний сайдын 2018 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн тушаалаар батлагдсан Эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 11 тоот тушаал болон Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн 10.1.3 болон 13.4.2 дугаар заалтын хүрээнд Улаанбаатар хотын дулааны сүлжээний дулааны алдагдлын бодит утгийг тогтоож, мөрдөгдөж байгаа нормтой тулгаж дүгнэлт гаргах.

ТАВИГДАХ ШААРДЛАГА:

Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн дамжуулах сүлжээний дулааны алдагдлын бодит утгийг тодорхойлох ажлын шалгуур үзүүлэлт.

- Туршилт судалгааны ажлыг гүйцэтгэх хуулийн этгээд нь: эрчим хүчний объектын Техник эдийн засгийн үзүүлэлт боловсруулах, зураг, төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл, эрчим хүчний иж бүрэн аудит хийх эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй байх.
- Дулааны шугамын дулааны алдагдлын туршилт судалгааны ажлыг ёмнө нь гүйцэтгэж байсан ажлын туршлагатай.
- Дулааны алдагдлыг тодорхойлох судалгаа, шинжилгээний батлагдсан арга зүйг эзэмшсэн.
- Шугамын дулааны алдагдлыг тодорхойлох лабораторын тоног төхөөрөмж, туршилтын дахин ашиглах жишэг сорьц, хэмжилтийн иж бүрэн багажны паркыг бүрдүүлсэн байх.
- Байгууллага танилцуулга хавсаргах.

Хянасан: YXX-ийн дарга

Э.Батмөнх

Ажлын даалгавар бичсэн: Хэмнэлтийн менежер

Д.Баяртогтох